

ДА ШЕН КҮЙ ПҮҮСИЙН БАЙГУУЛАГДСАН ОН ЦАГ ХИЙГЭЭД ГАЗАР ОРНЫ ТУХАЙД

Д.Базардорж

Товч агуулга: Өдгөө болтол монголчуудын сэтгэхүйд хадагдан үлдсэн Да Шен Күй пүүс чухам хэдийд, хэрхэн, хаана байгуулагдав? Энэхүү эргэлзээтэй асуудлуудын хүрээнд эргэцүүлж, түүний байгуулагдсан байх мадагтай цаг хугацааг 20 орчим жилийн хязгаарт базаж, анх байгуулагдах үеийн түүхэн нөхцөлийг нь дурдан гаргав. Түүнчлэн судлаачдын тэмдэглэдэгчлэн Улиастай хотод анх байгуулагдсан гэдэг нь ташиаарсан ойлголт болохыг тэмдэглээд уг пүүсийн байгуулагдсан газар орон хийгээд Да Шен Күйн төв пүүсний шилжилт хөдөлгөөнийг нягтлан үзэж зохих хэмжээгээр өөрсдийн үнэлэлтийг гарган дэвшүүлээ.

Түлхүүр үг: Да Шен Күй, Гүй Хуа, Улиастай, Энх Амгалан, Ван Шиан Чин

Удиртгал

ХҮП зууны үед Манжууд Ар, Өвөр Монгол болон Хятадыг эрхшээн захирах болсноор тэдгээрийн худалдааны харилцаанд үндсэн өөрчлөлт гарах түүхэн нөхцөл бүрэлджээ. Хэдийгээр эхэн үедээ Чин улс, төрийн бодлогынхоо үүднээс Монгол, Хятад хоёр ард түмний хоорондох аливаа нийгэм эдийн засгийн харилцаанд тодорхой хориг саад тавьж байсан ч түүхэн үйл явцтай уялдан цаг хугацаа улирах тусам энэхүү хуулиар тогтоосон хориг аажмаар суларч яваандаа цуцлагдсан байна.

Энэ нь юуны урьд хоёр ард түмний хоорондох эдийн засаг, худалдааны ашиг сонирголоор илэрхийлэгдэж байх учиртай ажээ. Ийм нөхцлөөс үүдэн Ар Монголд ирж худалдаалах сонирхолтой пүүс хоршоод дотор газар олноор байгуулагдах болсон нь төрийн хяналтын дор хийгддэг хилийн түр цагийн болон элчийн худалдаанаас огт өөр түүхэн шинэ үзэгдэл болж байлаа. Тухайн цагт хятад газар байгуулагдаж байсан худалдааны пүүс хоршоод нь үйл ажиллагааны шинэ нөхцөлд, төрийн ижил бус зохицуулалтын дор боловсрон хөгжиж 200 гаруй жил тасралтгүйгээр Ар, Өвөрмонгол болон бусад нутагт үйл ажиллагаа явуулж XX зууны эхний хагас хүргэжээ.

гарган мөн эл бичээсийг тус хийдийн ойролцоо орших Жан овогт нэгэн хятадаар уг эхийн загварыг дууриалган дахин сэргээлгэж нэгэн хувь хийлгээд уг сууринд байрлуулж, хуучин эхийг нь тус сүмийн агуулахад хураан хадгалуулжээ⁸.

Самбарын бичээснээс үндэслэвэл, Да Шен Күй пүүсийн байгуулагдсан он цагийн тухайд яг тодорхой зүйлийг хэлэхийн аргагүй боловч Да Шен Күй пүүс Найралт төвийн хөх луу жилд (1724 он) Гүй Хуаг-д (归化 Gui Hua одоогийн Хөх хот-Д.Б) үйл ажиллагаа явуулж байсныг бид төвөггүйгээр ойлгож болно. Тэгвэл энэхүү пүүс нь өдий хэмжээнд хүртлээ тодорхой цаг хугацааг туулсан байх нь эргэлзээгүй учир, үүнээс өмнө байгуулагдсан нь илэрхий байна. Энэ бол одоогоор судлаачдад олдоод байгаа тус пүүсний үүсэн байгуулагдсан цаг хугацааны асуудал дахь хамгийн нөлөөлөх баримжаа өгч байгаа сурвалж болох юм.

Мөн тус пүүсний байгуулагдсан хугацааг нягтлахад холбогдол бүхий хоёр баримтыг МУУТА-с шүүрдэн илрүүлснээ танилцуулъя. Эхний баримт нь, 1913 оны 12 дугаар сард Да Шен Күй пүүсний Халх Монгол дахь төв болох Улиастайн салбар пүүсний данжаад Баянжаргалын нэрээр, Гадаадын Хэргийг Бүгд Эрхлэн Шийтгэгч Яамаар уламжлан "...язгуурын чинээ ядуу цагаас эдүгээ хүртэл Халхын хишигийг хүртэж хүмүүжсэнээ ямагт сүслэн санаж..." Монгол улсын цэрэг, армид тусламж үзүүлэх тухай айлтгалыг Богд хаантанд өргөсөн айлтгал болох юм. Уг айлтгалын эхэнд, Да Шен Күй пүүс өөрийн түүхэн замналаа товч танилцуулахдаа "...Манай өчүүхэн пүүс Чин улсын Энх-Амгалангийн оноос үүсч..."⁹ хэмээн тэмдэглэсэн байна. Удаах баримт нь, Олноо Өргөгдсөний долдугаар он гурван сарын хорин таванд ГХБЭШЯ-нд Да Шен Күй пүүсний тэргүүлэгч Тиан Хуа Үй (田化育 Tian Hua Yu) -гээс өргөсөн өрийн нэхэмжлэх бичиг болох юм. Энэхүү бичигт "...бид ...Халхын газар хоёр зуу илүү он суусан..."¹⁰ хэмээн тэмдэглэгджээ.

Архивын эхний баримтаас, Да Шен Күй пүүс Манжийн Энх-Амгалангийн үед үүсэн байгуулагдсан гэдгийг мэдэж болно. Гэвч, 1661-1722 оны хооронд 61 жил төр барьсан хааны чухам аль үед нь, хэдийд байгуулагдав гэдэг нь тодорхойгүй ч, Энх Амгалангийн цаг үеэс өмнө болон сүүлд үүссэн хэмээх зарим саналуудад няцаалт болж байна. Удаах баримтаас, тус пүүс нь 1917 оноос урагш тоолвол 200 илүү жилийн өмнөөс Халх монголд суурьшжээ гэдгийг ойлгож болох юм. Энэ нь Да Шен Күй пүүс 1717 он буюу түүнээс хэдэн жилийн өмнөөс Халхад нэвтрэн үйл ажиллагаагаа явуулах болсон нь харагдаж байна.

⁸ 2010.06.05-нд Ширээт Зуу хийдийн Дэмч лам Баяраатай хийсэн хувийн ярилцлага.

⁹ МУУТА., ФА-8, Д-1, ХН-428, Н-1.

¹⁰ МУУТА., ФА-4, Д-1, ХН-149, Н-59

Дээрх гурван сурвалжийн мэдээг үндэслэвэл, Да Шен Күй пүүс нь Чин улсын Энх-Амгалангийн төрийн үед үүссэн бөгөөд 1717 он буюу түүнээс хэдэн жилийн өмнөөс үйл ажиллагаа нь Халхад нэвтэрсэн гэдгийг харж болохоор байна. Энэ нь тус пүүсний үүсгэн байгуулагдсан байж болох магадлалтай цаг хугацааны хойд хязгаарыг зааж байгаа юм. Тэгвэл энэхүү пүүсний үүсэн байгуулагдсан байх он цагийн эртний хугацааг тодруулах шаардлага гарч ирж байна. Иймээс дээрх баримтуудын бидэнд өгч байгаа мэдээллийг ийнхүү нэгтгээд судалгааны энэ хүрээнд шууд болон дам хамаарах бүтээлүүдийн дүгнэлтүүдийг эргэцүүлбэл доорх мэт.

Судлаачид Да Шен Күйг Ар Монголд хятадын худалдаа нэвтрэхэд орж ирсэн ууган пүүсүүдийн нэг байсан гэж үздэг. Иймээс бид Ар Монголд хятадын худалдаа хэдийд нэвтрэн орж ирсэн талаарх судлаачдын дүгнэлтийг анхааран үзэх хэрэгтэй.

Монгол улсын судлаачдаас Халхад хятадын худалдаа хэдийд нэвтэрсэн бэ гэдэг асуултыг тавьж үүндээ дорвитой хариулт өгсөн хүний нэг бол М.Санждорж абугай юм. Тэрээр XVIII зууны эхээр эсхүл мөн зууны сүүлчээр хятад худалдаачид нэвтэрсэн хэмээх өмнөх судлаачдын ташаа дүгнэлтүүдийг шүүмжлэн буруушааж¹¹, XVII зууны сүүлчээр нэвтэрсэн гэх зарим боломжит саналуудыг дэмжин¹², тухайн үеийн түүхэн нөхцөл байдлыг задлан шинжилж архивын холбогдох бусад баримт болон түүхэн эх сурвалж дэх шууд бус мэдээнд тулгуурлан "...Халхын хязгаарт цөмрөн орж ирсэн энэхүү цэргийг (Энх-Амгалангын-Д.Б) дагалдан хятадын монго хүүлэгч худалдаачдын түрүүч Халхад нэвтэрсэн бололтой"¹³ хэмээснийг холбогдох чиглэлээр нэгэн сэдэвт бүтээл туурвисан судлаач А.Очир дэмжсэн байдаг¹⁴. Бид ч эдгээр судлаачдын дэвшүүлсэн саналд бүрэн тал өгч байна. Чингэхдээ Да Шен Күй пүүс нь Халхад нэвтрэн орж ирсэн хятад худалдааны анхны пүүсүүдийн нэг байсан гэдэг нь чухам түүхэн тэр цагт нэгэнт үйл ажиллагаагаа явуулж байсан худалдааны пүүс байв уу? эсхүл, яг тухайн цаг үеийн шаардлага, түүхэн нөхцөлөөр шинээр бүрэлдэн төлөвшсөн пүүс байж уу? гэдгийг нягтлан гаргах хэрэгтэй болох юм.

Галданг дайлаар мордохоос өмнөх жилүүдэд Манжийн жанжин Фей Ян Гү (费杨古 Fei Yang Gu) -гийн удирдсан цэргийн томоохон хороо одоогийн Шан

¹¹ В.Болохин, Г.Е.Грумм-Гржимайло нарын бүтээл болон "БНМАУ-ын түүх" Нэгэн боть. УБ., 1954

¹² И.Г.Юрьев. К вопросу об иностранном капитале во Внешней Монголии до народно-демократической революции 1921 г. и в первые ее годы. Краткие сообщения Института востоковедения УИ. М., 1952, стр 55 Л.Гомбо. Манжийн үеийн албан гувчуур (1850-1910) УБ., 1960 тал 8

¹³ М.Санждорж. Халхад хятадын монго хүүлэгч худалдаа нэвтэрч хөлжсөн нь. (XVIII зуун) УБ., 1963, тал 27

¹⁴ А.Очир. Монгол-Хятадын худалдааны харилцаа. (XIX-XX зууны эхэн) УБ., 1995, тал 39

ши мужийн нутаг дахь Шүүрхий хаалганд (杀虎口 Sha Hu Kou) байрлаж байх үед Да Шен Күй пүүсийг үүсгэн байгуулагчид болох Ван Шиан Чин (王相卿 Wang Xiang Qing), Жан Жие (张杰 Zhang Jie), Ши Да Шүе (史大学 Shi Da Xue) нар энэхүү цэргийн хороонд тогооч, зарц зэрэг хар бор ажлыг хийж байжээ¹⁵. Тэд цөм Шан ши мужийн хүмүүс аж. Тухайн үед Ар Монголд өрнөсөн улс төрийн хямрал тэмцлээс дайжсан хэдэн арван түмэн Халх монголчууд Өндөр гэгээнийг дагалдан хилийн энэхүү зурвас газраар нутаглан сууж байлаа. Эдгээр халхууд зарим үед дотор хүмүүстэй хольцолдон сууж адуу малаар арилжаа солилцоо хийдэг байсан нь түүхэн сурвалжуудад тэмдэглэгдэн үлджээ.¹⁶ Энэ үедээ Ван Шиан Чин, Жан Жие, Ши Да Шүе нар Фей Ян Гү-гийн цэргийн өдөр тутмын хэрэгцээ болох хүнсний зүйлсийг монголчуудаас худалдан авдаг байсны зэрэгцээ өөрсдөө ч мөөг ногоо түүж түүнийгээ энэхүү цэргийн хүнсний хэрэгцээнд нийлүүлэн худалддаг байжээ. Тэд үргэлж хилийн боомтын зах, худалдаагаар явж цэргийн хүнсний хэрэгцээнд монголчуудаас хонь мал худалдан авах арилжаа наймаа хийдэг байсан болохоор бага багаар монгол үг хэлийг сурах болж, монголчуудын ёс заншил, амьдралын зан үйл болон арилжаа наймаа хийх арга барилыг нь ч мэддэг болцгоосон байна¹⁷.

Түүхэн энэхүү цаг үед Манж Чин гүрэн, Зүүнгарын Галдан бошогт хааны хоорондох зөрчил хурцдан их бага хэд хэдэн удаа дайтаж байлаа. Галдан бошогтыг нэгмөсөн устгахаар их цэргийг Энх-Амгалан өөрийн биеэр удирдан хөдөлгөхөөр болжээ.

1696 онд Манжийн их цэрэг гурван замаар Халхын нутагт нэвтрэн ороход Манжийн хаан зарлиг буулгаж, Фей Ян Гү-г "...хол дахиныг тохинуулагч их жанжсин болгож баруун замын их цэргийг тушааж..."¹⁸ Галдангийн эсрэг хөдөлгөсөн байна. Чин гүрний эзэн хаан өөрийн биеэр удирдсан энэ удаагийн их цэргийг дагалдуулан цэргийн хүнснийхээ хэрэгцээг шаардлагтай үед нь найдвартай хангаж байх үүднээс, нөгөө талаар цэрэг армийнхаа ачаа тээврийг хөнгөвчлөх зорилгоор хятад худалдаачдыг дагалдуулан авч явсан нь Халх Монголд биеэр ирж худалдаа хийгчдийн анхдагчид нь болсон байна. Гэхдээ энэ үедээ тэдгээр худалдаачид зөвхөн цэргийн хүнсний хэрэгцээнд зориулсан

¹⁵ Да Шен Күй пүүс. Өвөрмонголын соёл түүхийн материал, дугаар 12, Өвөрмонголын соёл түүхийн номын дэлгүүр тархаав. 1984, тал 3 《旅蒙商大盛魁》内蒙古文史资料, 第十二辑, 内蒙古文史书店发行, 1984年, 页3.

¹⁶ М.Санждорж. Халхад хятадын мөнгө хүүлэгч худалдаа нэвтэрч хөлжсөн нь УБ., 1963 тал 26

¹⁷ Да Шен Күй пүүс. Өвөрмонголын соёл түүхийн материал, дугаар 12, Өвөрмонголын соёл түүхийн номын дэлгүүр тархаав. 1984 (旅蒙商大盛魁) 内蒙古文史资料, 第十二辑, 内蒙古文史书店发行, 1984年)

¹⁸ Биеэр дайж өрнө, умрын газрыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо. Хайлаар. 1992, XIX боть, тал- 293

худалдааг манжийн армитай хийдэг байсан бололтой. Учир нь, “Манжийн засгийн газраас цэргүүдэд тодорхой хэмжээний цалин олгодог, цэргүүд тэр мөнгөөр нь худалдаачдаас зохион байгуулалттайгаар хүнсний зүйл худалдан авдаг байв¹⁹.” Энэ үед Ван Шиан Чин, Жан Жие, Ши Да Шүе нар их цэргийг дагалдан дамнуур дамнаж аму будаа зэргийн арилжаа наймаа хийн явж байжээ. Тэд хэдийгээр хөрөнгө бэл багатай, эрхлэх ажил нь их биш голчлон Манжийн их цэргийн хүнсний хэрэгцээнд нийлүүлэх зүйлийг худалдаж байсан ч хятад судлаачын тэмдэглэсэнчлэн “...наймаа арилжаа нь цэгц найдвартай, үйл ажиллагаа нь үйлчилгээ сайтай...”²⁰ байсан болохоор дэгжин хөгжих их үйл хэргийнхээ анхны шанг татаж байв.

Чин улсын их цэрэг Галдан бошогтыг сарниулан цохисоны дараа баруун замын цэргийн гол хүчнээ Далан хар уулын өмнө 1697 оны сүүлчээр шилжүүлэн байрлуулахад Ван Шиан Чин нар Шүүрхий хаалганаас хүнс эд бараагаар энэхүү их цэргийн хэрэгцээг зөөвөрлөн хангаж нийлүүлэх болсон ажээ. Тэд ч Галдан Бошогтыг дайлах Манжийн их цэргийн ар тал болж урт замын бэрх аяныг хийхдээ ирээдүйд үүсэн бий болох асар том худалдааны байгууллагын уг суурийн шанг тавих болсон нь эргэлзээгүй юм. Чухам энэ үеэс эхлэж тэд хөрөнгийн “анхны хуримтлал”-аа бий болгож, өөрсдийн байгаа боломжит нөхцөл байдлын давууг ухамсарлан ашиглаж, нэгдсэн үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэрт орох санаа төрсөн гэж үзүүштэй. Иймээс “...тэд удалгүй Шүүрхий хаалганы хэдэн худалдаачидтай нийлж “Жи Шен Тан” (吉盛堂 Ji Sheng Tang) хэмээх жижиг худалдааны нэгж нээсэн нь хожмын Да Шен Күй нь үндэс суурь болжээ.”²¹ Энэхүү Жи Шен Тан-хэмээх пүүсээ “...Энх Амгалангийн сүүлчийн жилүүдэд Да Шен Күй хэмээн өөрчлөн нэрийджээ”²². Ер нь түүхэн энэ цаг үед Манжийн төрийн дэмжлэгийн дор хожмын Ар Монгол дахь Хятадын томоохон пүүсүүдийн уг суурь тавигдсан байна.

Энх-Амгалан умарш мордохоос өмнө Да Шен Күй пүүсийн үүсгэн байгуулагчид, тэрхүү их цэргийн баруун гарын ар талд өдөр тутмын цэргийн

¹⁹ А.Очир. Монгол-Хятадын худалдааны харилцаа. (XIX-XX зууны эхэн) УБ., 1995, тал 12

²⁰ Дэн Жиү Ган. “Да Шен Күй пүүс” Роман. Судлаачын оршил үг. Хятадын Хуабао хэвлэлийн газар. 2008. 邓九刚：小说《大盛魁商号》. (序言部分) 中国画报出版社, 2008 年.

²¹ “Да Шен Күй пүүс” Өвөрмонголын соёл түүхийн материал, дугаар 12. Өвөрмонголын соёл түүхийн номын дэлгүүр тархаав. 1984, тал 3-4. (旅蒙商大盛魁) 内蒙古文史资料, 第十二辑, 内蒙古文史书店发行, 1984 年, 页 3-4). Нин Ёу Чан. “Чин гүрний үеийн Монгол дахь хамгийн том явуул худалдаа-Да Шен Күй” Соёл, түүхийн охь сэтгүүл. 1996 оны дугаар 3, тал 31. (宁有常, 《近代最大的旅蒙商号大盛魁》文史精华, 1996 年, 第 03 期, 31 页)

²² Шиа Уй, Гүо Хү. “Тэмээн жингийн хонхны дуун дахь худалдааны вант улс-Да Шен Күй” Шан ши-гийн залуучууд (Шинэ Шан ши-гийн худалдаачин) сэтгүүл, 2008 оны дугаар Z1, тал 108. 夏雨, 郭虎, 《大盛魁——驼铃声中的商业帝国》山西青年 (新晋商) 2008 年第 Z1 期, 页 108

хүнсний хэрэгцээг хангах үүрэг бүхий албанд ажиллаж байх үедээ бага хэмжээний арилжаа наймаа эрхэлж байсан тэр үеийг уг пүүс үйл ажиллагаа эхэлсэн хэмээн үзэх нь учир дутагдалтай юм. Учир нь, энэ үедээ тэд бага сага зүйлийг арилжин явдаг асан тухайн цагийн олон жижиг худалдаачдаас ялгарч чадахгүй байсан бөгөөд арилжаа худалдааны зохион байгуулалтад нэгдээгүй, өдөр тутмын урсгал үйл ажиллагаатай байжээ хэмээн үзэж болно. Чухам иймээс, тэд Жи Шен Тан хэмээх худалдааны жижиг нэгж нээсэн үеийг л Да Шен Күйгийн үйл ажиллагааны эхлэлт хэмээн үзэх нь илүү бодитой бөгөөд тодорхой мэдээ болох юм.

Өөрөөр хэлбэл, Да Шен Күй пүүсийн байгуулагдсан байх магадлалтай цаг хугацааны өмнө хязгаарыг 1697 он буюу түүний дараах хэдэн жилд хамааруулж үзвэл илүү боломжтой мэт.

2. Да Шен Күй пүүсийн байгуулагдсан газар орны тухайд

Да Шен Күй пүүс чухам хаана байгуулагдсан талаарх судлаачдын дүгнэлтүүд эргэлзээ төрүүлж байна. Ямар нэгэн хэмжээгээр хятадын худалдаа мөнгө хүүлэл болон Да Шен Күй пүүсийн талаар хөндсөн судалгаанд тус пүүс нь эхэндээ Улиастайд суурьшиж байгаад яваандаа Хөх хотод төв пүүс нь шилжин ирсэн хэмээн тэмдэглэсэн байдаг.²³ Энэ нь, Да Шен Күй пүүс чухам анх Улиастайд байгуулагдсан уу, эсхүл хожим Улиастайд хэсэг төвлөн суурьшиж байв уу гэдгийг салгаж ойлгоход бэрхтэй хоёрдмол санааг агуулжээ. Гэхдээ, эдгээр бүтээлийг агуулгын хүрээнд нь харахад Да Шен Күй пүүсийг Улиастайд байгуулсан гэх санал болов уу хэмээн ойлгогдоно.

Дээрх дэвшүүлсэн саналууд нь их л эргэлзээтэй, илэрхий ташаарсан болох нь тодорхой байна. Учир юун хэмээвээс, Улиастай хотын үүсэлийг хөндөн үзсэн судалгааны бүтээлүүдэд, энэхүү хот 1733 онд манжийн төрийн цэрэг дайны бодлогоор байгуулагдсан хэмээн тэмдэглэж байна. Тухайлбал, Ц.Сономдагва гуай “Энэ жанжны газар нь (Улиастайн жанжны газар-Д.Б) 1733 оны үед байгуулагдсан бололтой”²⁴ хэмээн барагцаалсан байхад түүхч М.Санждорж Улиастай хотын үүслийн тухай тусгай өгүүлэлдээ түүхэн

²³ “Да Шен Күй пүүс” Өвөрмонголын соёл түүхийн материал, дугаар 12, Өвөрмонголын соёл түүхийн номын дэлгүүр тархаав. 1984, тал 4 《旅蒙商大盛魁》内蒙古文史资料, 第十二辑, 内蒙古文史书店发行, 1984年, 页4. “Монгол үндэстний нэвтэрхий түүх” ӨМИС-ийн хэвлэлийн хороо. 4-р боть, 1993, тал 287 《蒙古民族通史》内蒙古大学出版社, 第四卷 1993年, 287页. Дарьжав. “Монголын түүхийн товч” Төвийн Үндэстний Их Сургуулийн хэвлэлийн хороо, 2006, тал 285 达力扎布; 《蒙古史纲要》中央民族大学出版社, 2006年, 页285. А. Очир. Монгол Хятадын худалдааны харилцаа. (XIX-XX зууны эхэн) УБ., 1995, тал 38, Эсрэгсан, Сайжрах. Монголын арилжаа худалдааны хөгжлийн түүх. Ляонингийн Үндэсний Хэвлэлийн Хороо. 2002 тал 340, Монгол Улсын Түүх. Дөтгөөр боть. УБ., 2003, тал 227.

²⁴ Ц.Сономдагва. Манжийн захиргаанд байсан үеийн Ар Монголын засаг захиргааны зохион байгуулалт. УБ., 1961 тал 29

сурвалжид тэмдэглэгдсэн Манжийн Найралт Төв төрийн хааны зарлигт тулгуурлан "...1733 онд Улиастайн цэргийн хот байгуулагджээ"²⁵ хэмээн батлан өгүүлжээ. Нөгөөтэйгүүр тус хотыг өөр цаг үед байгуулагдсан гэх санал дэвшүүлсэн судлаач үгүй байна. Иймд, Улиастай хот 1733 онд байгуулагдсан нь түүхийн судалгааны хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн асуудал болох юм.

Бид өмнөх хэсэгт Да Шен Күй пүүсийн байгуулагдсан он цагийг нягтлан үзэхдээ, тодорхой түүхэн үеийн хорь хүрэхгүй жилийн дотор хамаатуулан өгүүлсэн билээ. Энэ дүгнэлтэнд тулгуурлан ухвал, тухайн цагт үүсэн бүрэлдээгүй хотод Да Шен Күй байгуулагдсан байж таарах уу? гэдэг асуулт гарч ирж байна. Энэ асуулт нь өөрөө судлагдахуун болгож байгаа уг пүүс яавч Улиастайд үүссэн байх бололцоогүйг харуулах юм. Харин Да Шен Күй пүүсийг үндэслэгчид болох Ван Шиан Чин нар Шүүрхий хаалганы хэдэн худалдаачинтай нийлэн Фей Ян Гү-гийн их цэргийн суурьлан байсан газрыг бараадан Далан хар уулын өвөрт өөрийн пүүсийг байгуулж, улмаар ХҮИИ зууны эхээр Халхын нутагт ээлж дараалан байгуулагдах болсон цэргийн суурингуудийг дагалдаж явсан бололтой. Хожим 1733 онд Манж Чин гүрэн Зүүн гарын хаант улс, Халхын хилийн уулзвар газарт Улиастайн хэмээх байнгын цэрэгтэй, цэргийн захиргааны том хуаранг байгуулж энэхүү цэргийн хүнс хэрэглэлийг худалдаачдаас авч ханган нийлүүлэхээр болсон байна. Иймээс багагүй тооны хятадын пүүс хоршоод тэдгээрийн аж амьдралд үйлчлэх сонирхолд автжээ. Чухам энэ л үед Да Шен Күй пүүс нь Улиастайд төвлөн суурилсан байх бололцоотой болох юм.

3. Да Шен Күйн төв пүүс Улиастайгаас шилжсэн он цагийн тухайд

Тус пүүс Улиастайд ийнхүү суурилсанаас хойш чухам хэдүйд Гүй Хуа руу эгэн шилжсэн талаар хятадын хоёр судлаач саналаа дэвшүүлсэн байдаг. Судлаач Нин Ёу Чан (宁有常 Ning You Chang) Да Шен Күйн төв пүүсний байршлын талаар цухас өгүүлэхдээ "...барагцаагаар Түгээмэл Элбэгтийн үед (1851-1861 Д.Б) төвөө Гүй Хуа хотод шилжүүлсэнээр Улиастай нь түүний нэгэн салбар пүүс болжээ"²⁶ хэмээсэн байхад судлаач Тиан Шү Мао (田树茂 Tian Shu Mao) Да Шен Күйн "Төв пүүс XIX зууны эхээр Гүй Хуа-д шилжин ирсэн..."²⁷ хэмээн өөр хоорондоо зөрүүтэй саналыг тэмдэглэжээ. Ямартаа ч энэ талаар үнэлэлт дүгнэлт өгсөн нь сайшаалтай хэрэг боловч эдгээр судлаачид

²⁵ М.Санждорж. Улиастай хотын байгуулагдсан нь. *Studia ethnographica*. Tomus II. УБ., 1965 тал 43-44

²⁶ Нин Ёу Чан. "Чин гүрний үеийн Монгол дахь хамгийн том явуул худалдаа- Да Шен Күй" Соёл түүхийн охь сэтгүүл. 1996 оны дугаар 3, тал 31 宁有常. 近代最大的旄蒙商号大盛魁. 文史精华, 1996年, 第03期, 31页.

²⁷ Тиан Шү Мао. "Да Шен Күй ба Чи шиан" Сар тутмын соёл, түүх сэтгүүл. 2006 оны дугаар 7, тал 122 (田树茂. 大盛魁与祁县. 文史月刊, 2006年, 07期, 122页)

ямар эх сурвалжаас үндэслэн ийнхүү дүгнэснээ заасангүй. Нөгөө талаар уг пүүсний шилжилт хөдөлгөөнийг өөр бусад бүтээлүүдэд тэмдэглээгүй, яг тодорхойлох баримт одоогоор илрээгүй ч, Да Шен Күй пүүсийн төв нь Улиастайгаас Гүй Хуйд шилжиж ирсэн нь мадаггүй болохоор бид дээрх дүгнэлтүүдийг нягтлан үзсэнээр дараах гаргалгааг хийж болох байна.

Бидний бодоход эхний санал нь цаг хугацааны хувьд хэтэрхий хойш татсан агаад яавч Түгээмэл Элбэгтийн үе хүртэл тус пүүсний төв нь Улиастайд суурьшаар байсан бололцоогүйг харж болно. Энэ үед Да Шен Күйн үйл ажиллагаа хэдүйн тогтворжоод зарим талаар бууран доройтох хандлагтай болсон байдаг. Нөгөө талаар дотор газар болоод Ар, Өвөр Монгол, тухайн үеийн Чин гүрний баруун хязгаар нутгийг хамарсан өргөн цар хүрээний үлэмж том байгууллага байсан учир бараа гүйлгээг зангидан барих төв газар нь Улиастайд байх бололцоогүйг харуулах юм. Өөрөөр хэлбэл өргөжин тэлж үйл ажиллагаа нь идэвхжсэн түүхэн энэ цаг үед Улиастай хот нь тус пүүсний худалдаа арилжааны хүрээний хойд хэсгийн төв байж болохоос нийт пүүсний хэмжээнд төв байж арилжаа гүйлгээг оновчтой зохион байгуулах газар зүйн орчин болж чадахгүй болсон үе юм.

Иймээс хоёрдугаар саналыг нягтлан үзье. Да Шен Күй пүүсийн талаарх голлох судалгааны бүтээлд Сайшаалт Ерөөлтийн эхний жилүүдэд тус пүүсний тэргүүлэгч "...*Чинь Юэй (秦越 Qin Yue) өөрийгөө болон Улиастай, Ховд, Бээжин зэрэг газрын хэд хэдэн салбар пүүсийн данжаад нараа отог, жинсээр шагнуулж чадсан*"²⁸ хэмээжээ. Судалгааны энэхүү мэдээ бол тухайн цагт Улиастай нь салбар пүүс болсон гэдгийг илтгэн харуулах бөгөөд XVIII зууны сүүл, XIX зууны эх гэхэд тус пүүс төвөө шилжүүлсэн байхыг харуулж байна. Энэхүү Чинь Юэй гэгч нь Тэнгэр Тэтгэгчийн сүүл, Сайшаал Ерөөлтийн эхний жилүүдэд Да Шен Күй пүүсийн тэргүүлэн ажиллаж байхдаа Чин гүрний засгийн газраас өөрийн хязгаар, зах нутгуудын эрх мэдэл бүхий язгууртад болон төвийн байгууллагуудтай чөлөөтэй харилцаж болох зөвшөөрөл бүхий маш цөөнөөр, хатуу чанга хяналттайгаар олгож байсан эзэн хааны тамгатай төрийн тусгай зөвшөөрлийн бичиг болох "луут тамга"-г олж аван, Да Шен Күйн зохион байгуулалт, дүрэм журамыг шинэчлэн тогтоосноор үйл ажиллагааных нь хүрээг үлэмж хэмжээгээр өргөтгөсөн байдаг²⁹. Тэгэхлээр энэ хүний удирдлагын үед тус пүүс зохион байгуулалтын өөрчлөлтийг хийхдээ пүүснийхээ байршлыг ч оновчтой газар шилжүүлэн шинээр хувиарласан байж болох юм. Тэр үеэс эхлэн Улиастайд байсан пүүс нь Да Шен Күйгийн Ар Монгол дахь хамгийн том салбар пүүс болон хувирсан бололтой. Өөрөөр хэлбэл,

²⁸ "Да Шен Күй пүүс" 内蒙古文史资料, 第十二辑, Өвөрмонголын соёл түүхийн материал, цуврал 12, 1984, тал 12 旅蒙商大盛魁. 内蒙古文史资料 第十二辑. 1984 年. 页 12

²⁹ Мөн тэнд

хоёр дахь санал бол тус пүүсний төвийн шилжилт хөдөлгөөний талаар оновчтой заажээ хэмээн үзэж болохоор байна.

Дээр өгүүлсэн бүгдийг хураангуйлбал, Да Шен Күй пүүс 1697-1717 оны хооронд Гүй Хуа-д буюу эдүгээгийн Хөх хотод байгуулагджээ. Харин 1733 онд Улиастайд цэргийн хүрээ байгуулагдан манж, хятад хүн олноор сууж, томоохон хуаран болоход уг цэргийн баазыг түшиглэж худалдаа арилжаа хийн цаашид Ар Монголд бэхжих таатай нөхцөл бүрдсэн учир Да Шен Күй төв пүүсээ тийш шилжүүлэн хэсэг хугацаанд үйл ажиллагаа явуулж байгаад XIX зууны эхээр бүтэц, үйл ажиллагааны өөрчлөлтийн улмаас Гүй Хуа руу эргэн шилжжээ хэмээн үзэх нь зүйтэй болов уу. Чингэхдээ тухайн түүхэн нөхцөл байдал дахь Манжийн төрөөс авсан цэрэг дайны бодлого, үйл ажиллагаа нь энэхүү пүүсийн бүрэлдэн хөгжихөд таатай нөлөө үзүүлж, цаашдын үлэмж том худалдааны байгууллага болон дэлгэрэх үндсэн шалтгаан нь болсон ажээ.

Abstract: In this paper the issues related to the business Da Shen Qui, when and where it was established and by whom it was founded were brought up. Making the context of the writing on the commemorative board that was given from the business and has been reserved until now in the Shreet Zuu monastery base of the research, enriching it with few but new archive materials that were newly founded and relying on the achievement of the research works we tried to make your conclusion.

By doing this we framed the time of the establishment of the business Da Shen Qui in 20 years of the specific historical time and concluded that the place of the foundation is not in Uliastai that the researchers believed to be but in Gui Hua, Huh Hot of nowadays.